

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 4-р сарын 30 өдөр

Улаанбаатар хот

“Силк Нэт” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2019 оны 4-р сарын 30 –ны өдрийн 14 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Олимпын гудамж, Реженси байр 314 тоотод ирсэн хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Хурлыг тус компанийн Гүйцэтгэх Захирал О.Амартүвшин нээв.

Гүйцэтгэх Захирал О.Амартүвшин :

-Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид та бүхэнд талархал илэрхийлье. Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар нийт 4 асуудал хэлэлцэнэ. Та бүхэнд тооллогын комиссоос гаргасан хурлын ирцийг танилцуулъя. Компанийн нийт 374,018 ширхэг хувьцааны 90.2% буюу 337,624 ширхэг хувьцааг эзэмшигчид ирсэн тул хурлыг хүчинтэйд тооцож эхлүүлье.

Хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон бусад төсөл төлөвлөгөөг батлах
3. Ногдол ашиг хувиарлах эсэх тухай тайлагнах
4. Бусад

Хурлын дэгийг танилцуулъя. Хуралаар хэлэлцэгдэх асуудлын жагсаалтын дагуу явагдана. Ингээд хурлаар хэлэлцэх эхний асуудал болох “Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан” – гийн талаар Гүйцэтгэх захирал О.Амартүвшин танилцуулна.

Гүйцэтгэх захирал, хурлын дарга О.Амартүвшин :

“Силк Нэт” ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд бэлтгэлээ.

“СилкНэт” ХК-ийн 2018 оны үйл ажилагааны тайлан

Силк Нэт ХК-ийн 2018 оны үйл ажиллагааны тайланг хувь нийлүүлэгчдийн ээлжит хуралд бэлтгэлээ. Тус онд манай компанийн хувьд 2017 онд зорьж эхлүүлсэн үйл

ажиллагаануудаа үргэлжлүүлэх, Монголын мэдээлэлийн технологи, Финтекийн салбарт судалгаа өрнүүлсэн жил боллоо.

2018 онд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг дэлгэрүүлэн авч үзвэл, дараах байдалтай байна:

1. Компанийн бүтэц, зохион байгуулалт

Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв зэрэг газруудад байсан урьд жилүүдийн гишүүнчлэл, хувьцаа хадгалалтын төлбөрүүдийг төлж барагдуулсан. Үндэсний аудитын Мэжик Аудит Консалтинг компаниар 2018 оны санхүүгийн аудитын тайланг хийлгэсэн.

2. Хөрөнгө оруулалт

Мэдээлэлийн технологийн тодорхой хөрөнгө оруулалтын төслийн танилцуулга хөрөнгө оруулагчдад танилцуулсан. Цаашид нэмэлт хөрөнгө оруулалт татах чиглэлээр үндэсний брокер дилэрийн компани Евразиа Капитал Холдинг ҮЦК-тай хамтран ажиллаж байна.

Криптовалютын судалгаа, олборлолтыг турших үйл ажиллагаанд төслийн санхүүжилтийн бага хүүтэй зээлийг хөрөнгө оруулалтын компаниас босгосон.

3. Хамтын ажиллагаа, түншлэл

Компанийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа мэргэжлийн зөвлөх үйл ажиллагааны хүрээнд эхний ээлжинд үндэсний компаниудтай хамтын ажиллагаа түншлэлийн гэрээ байгуулсан. Эдгээр компанид татварын мэргэшсэн зөвлөгөө үзүүлдэг компани, уул уурхайн ханган нийлүүлэлтийн компани болон мэдээлэлийн технологийн зөвлөгөө үзүүлэгч зэрэг төрөл бүрийн салбарын үндэсний компаниуд багтаж байна.

Үндэсний финтек стартап компанийг зөвлөн ажиллаж байна. Энэхүү финтек стартап зах зээлийн гараа амжилттай болсон тохиолдолд гадны зах зээл рүү гаргах үйл ажиллагааг Силк Нэт ХК хариуцан ажиллахаар хамтарч байна.

4. Үйлчилгээ

Мэдээлэлийн Технологийн Зөвлөх үйлчилгээний хүрээнд одоогийн байдлаар Америкийн Монгол Судлалын Төв болон Пипл ин Нийд зэрэг олон улсын байгууллагуудад Ай Ти шийдлийн зөвлөгөө өгөх, оффис ай ти үйлчилгээг үзүүлж байна.

Оффис ай ти үйлчилгээг сонирхсон гадаадын суурин төлөөлөгчийн газруудад зориулсан онлайн танилцуулга бэлтгэж байна. Үйлчилгээний багцыг дараахь байдлаар тодорхойлсон:

Дуудлагаар үйлчилээ үзүүлэх	Үндсэн багц	Премиум багц	Бүтэн үйлчилгээний багц
-Компютерын алдаа олж засварлах	-Компютерын алдаа олж	-Компютерын алдаа олж засварлах	-Компютерын алдаа олж засварлах

- Сүлжэний алдаа олж засварлах - Програм суулгах янзлах - Принтерын алдаа олж засварлах - Зөвөлгөө - Интернет хурдын алдааг олж засварлах - Антивирус суулгах/ устгах	засварлах - Сүлжэний алдаа олж засварлах - Програм суулгах янзлах - Принтерын алдаа олж засварлах - Зөвөлгөө - Интернет хурдын алдааг олж засварлах - Антивирус суулгах/ устгах	- Сүлжэний алдаа олж засварлах - Програм суулгах янзлах - Принтерын алдаа олж засварлах - Зөвөлгөө - Интернет хурдын алдааг олж засварлах - Антивирус суулгах/ устгах - Дотоодын cloud сервер суулгах - Цахим хуудасын аюулгүй бадлыг улираалаар шалгах - Хүсэлтээр цахим хуудасыг шинэчлэх	- Сүлжэний алдаа олж засварлах - Програм суулгах янзлах - Принтерын алдаа олж засварлах - Зөвөлгөө - Интернет хурдын алдааг олж засварлах - Антивирус суулгах/ устгах - Дотоодын cloud сервер суулгах - Цахим хуудасын аюулгүй бадлыг улираалаар шалгах - Хүсэлтээр цахим хуудасыг шинэчлэх - Цахим хуудсын мэдээллийн менежмент - Байгууллагын мэдээлэл технологийн стратегийн зөвлөгөө
--	---	--	---

Мөн гадны болон дотоодын компаниудад вэбэд суурилсан програм хангамж хөгжүүлэх болон мэдээлэлийн технологийн шийдлийн зөвлөгөөг өгч байна.

1. Судалгаа шинжилгээ, шинэ төсөл

Финтек технологийн хүрээнд блокчэйн технологи болон криптовалютыг судалж, Монголын банк санхүүгийн салбар дах зээлийн үйл ажиллагаа, борлуулалтын сүлжээ болон улсын системүүдийн уялдаа холбоо зэргийг судалж байна.

Харин цаашид буюу 2019 онд хэрэгжүүлэх төвөлөгөөний хувьд:

Силк Нэт ХК-ийн зүгээс 2019 онд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж байна.

1. Бүтэц зохион байгуулалт

- Компанийн үйл ажиллагааг амжилттай үргэлжлүүлэхэд зайлшгүй шаардлагатай удирлагын баг, зөвлөх баг болон хөгжүүлэгчдийн багийг бүрдүүлэх.
- Цалин урамшуулалын системийг тодорхой болгох
- Нэмэлт хөрөнгө оруулалт татах

2. Програм хангамж хөгжүүлэлт

- Зөвлөх үйлчилгээний платформыг хөрөнгө оруулагчидтай тохиролцсоны дагуу хөгжүүлж эхлэх.
- Их Өгөгдөл боловсруулах чиглэлээр судалгаа хийж, бизнесийн үйлчилгээ болгон Монголд нэвтрүүлэх.
- Бусад компанийн захиалгын дагуу вэбэд суурилсан програм хангамж, шийдэл хөгжүүлэх, нэвтрүүлэх

3. Мэдээлэлийн Технологийн Худалдаа

- Мэдээлэлийн Технологийг нэвтрүүлэх, нутагшуулахтай холбоотой тоног төхөөрөмж, програм хангамжийн худалдаа эрхлэх

4. Мэргэжлийн Зөвлөх Үйлчилгээ

- Бизнесийн удирдлага, Төслийн удирдлага, Мэдээлэлийн Технологи болон Бизнес стратегитэй холбоотой мэргэжлийн зөвлөх үйлчилгээний багцтай болох
 - Бизнесийн автоматжуулалт, өөрчлөлтийн удирдлагын чиглэлээр зөвлөгөө өгөх
- Санхүүгийн тайлангийн хувьд:

Силкнэт ХК-ийн 2018 оны нийт борлуулалт 49,3 сая төгрөг байсан боловч 12,3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан. Нийт 157,6 сая төгрөгийн хөрөнгийн дүнтэй ба эдгээр хөрөнгө нь бүгд эргэлтийн хөрөнгө юм. Үүнээс 57,6 сая төгрөг нь мөнгөн хөрөнгө, 95,9 сая төгрөг нь бараа материал, 4 сая төгрөг нь бусад санхүүгийн хөрөнгө байна. Нийт өр төлбөрийн дүн болох 124,7 сая төгрөгийн 123,8 сая нь урт хугацаат өр төлбөр бөгөөд үлдсэн дүн буюу 0,9 сая төгрөг нь татварын өр юм. Эздийн өмчийн хувьд өөрчлөлт байхгүй ба 37,4 сая төгрөг байна.

Хурлын дарга О.Амартүвшин: Та бүхэнд асууж тодруулах зүйл байна уу. Та бүхэнд тараагдсан байгаа материалтай танилцана уу.

Хувьцаа эзэмшигчид: Байхгүй ээ. Цаашид хэрэгжүүлэх төсөл төлөвлөгөөг бүрэн дэмжиж байна.

Хурлын дарга О.Амартүвшин: Компани ашигтай ажиллаагүй тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн болно.

Хурлын дарга О.Амартүвшин:– Та бүхэнд хурлаар хэлэлцэгдсэн асуудлаас гадна хэлэх санал, хүсэлт байна уу? Өөрсдийн бодлоо чөлөөтэй илэрхийлээрэй.

Хуралд оролцогчид – Нэмж хэлэх зүйл алгаа.

Хурлын дарга О.Амартүвшин: – За тэгвэл бидний өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудал дуусч байна. Ингээд санал хураалтаа эхлүүлье.

Хувьцаа эзэмшигчдээс өөр санал, асуулт гараагүй тул санал хураалтыг эхлэв.

Саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсөний дараа хурлын дарга Хувьцаа эзэмшигчдэд хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

Тооллогын комиссын дүнг тооллогын комиссын дарга танилцуулав.

Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож, нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна. Хүчингүй саналын хуудас гараагүй.

“Силк Нэт” ХК-ийн 2019 оны 4 сарын 30-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлав.
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хурлаар хэлэлцэгдсэнээр батлав.

Хурлын дарга О.Амартүвшин:– Энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байна. Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсье. Баярлалаа.

“Силк Нэт” ХК – ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 15.40 цагт дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:

Б.Бямбасүрэн

Хянасан: Хурлын дарга

О.Амартүвшин

